



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, 55 дугаар зүйлийн 55.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал праявит экүити хувийн ХОС” ХХК-ийн дүрэмд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын таван өдрийн дотор мэдэгдэхийг “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК (Г.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК (Г.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН